



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/424

Булган сум

Хадлан, тариалангийн
талбайг хамгаалах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тариалангийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.3, 54 дүгээр зүйлийн 54.3, Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-136, А-158, А-210 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тариалангийн талбайд үр суулгаснаас ургац хурааж дуусах хүртэлх, Газрын нэгдмэл санд бүртгэгдсэн хадлангийн талбайд хадлан авч дуусах хүртэлх хугацаанд мал, амьтан бэлчээхийг хориглосугай.

2.Тариалангийн талбайн ургацыг мал, амьтдаас хамгаалах, сахиул, эргүүлийг албан ёсоор томилон ажиллуулах, хашаа, тор барих ажлыг зохион байгуулж, тариалангийн талбайн ойролцоо нутагладаг буюу мал талбайд орж болзошгүй айл өрхийн малчидтай гэрээ байгуулж, ногоон тэжээл тариалан малчдад дэмжлэг үзүүлж харилцан тохирч ажиллахыг тариалан эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан маргаан зөрчлийг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга болон Ургацын комиссын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010421